



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2009 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 315

Улаанбаатар хот

┌ Тушаалд өөрчлөлт оруулах тухай ┐

Монгол улс, Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Солонгос Ард Улсын Засгийн газар хооронд 2009-2011 онд соёлын талаар хамтран ажиллах төлөвлөгөө болон Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Оюутан суралцуулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 4 дүгээр тушаалын дагуу Монгол улсын их сургуулийн бэлтгэл ангид суралцаж байгаа Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Солонгос Улсын иргэн Ri Su Yon, Jon Won Hyok, Ryo Il Gwang нарын суралцах хугацааг 10 сар гэснийг 12 сар болгож өөрчилсүгэй.

2. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/, Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/ нарт тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБАЯР